

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-12
1. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	5-7
2. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх, “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	7-12

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 04 дүгээр сарын 30-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 45 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Б.Батцэцэг, П.Ганзориг, Г.Дамдинням;
Чөлөөтэй: Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, Б.Заяабал, Д.Пүрэвдаваа;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, Б.Түвшин.

Нэг. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, Х.Ганхуяг, Н.Алтанхуяг нар үг хэлэв.

Ц.Даваасүрэн: Тогтоолд Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Л.Мөнхбаясгалан, Ж.Баясгалан, Х.Ганхуяг нарыг нэмж оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх, “Нэр дэвшигчийн сонсголын товч тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд Б.Бат-Эрдэнийг нэр дэвшүүлэх саналыг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Р.Мөнхтөрийг нэр дэвшүүлэх саналыг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Б.Ариунболдыг нэр дэвшүүлэх саналыг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг нар тус тус танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.6 дахь заалтын дагуу нэр дэвшигч нэг бүрээр санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Болдбаатарын Ариунболдыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 10
Бүгд: 15
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Бөхбатын Бат-Эрдэнийг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 8
Бүгд: 15
46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 8
Бүгд: 15
46.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулгын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулгын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 8
Бүгд: 15
46.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Улсын Их Хурлын гишүүдийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гараад байгаа тул санал хураалтыг гар өргөж явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

Ц.Даваасүрэн: Дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Горимын санал дэмжигдсэн тул Бөхбатын Бат-Эрдэнийг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Равжирын Мөнхтөрийг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 10
Бүгд: 15
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 6

Бүгд: 15

60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 25 минут үргэлжилж, 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН

ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН

БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН

ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим, 11 цаг 45 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Гишүүд ээ, хуралдаанаа үргэлжлүүлье. 25 гишүүнээс 13 гишүүн ирж, ирц 52 хувьтай байна.

Хэлэлцэх асуудлыг би та бүхэнд танилцуулъя. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа.

Би та бүхэнд танилцуулаадахъя. Ямар өөрчлөлт орж байгааг нь. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай асуудал дээр саналтай гишүүн байна уу. Би эхлээд танилцуулаадахъя.

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор байгуулагдсан Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Үндэсний Аудитын газрын Оюутолгойн төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэж байгаатай холбогдуулан санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Л.Мөнхбаясгалан нарыг нэмсүгэй.

2.Энэ тогтоолыг 2025 оны 4 дэх сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. гэсэн ийм тогтоол байна.

Тогтоолтой холбогдуулаад, тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна уу. Алга байна. Саналтай гишүүн байна уу. Алтанхуяг гишүүнээр тасалъя. Баясгалан гишүүн саналаа хэлье.

Ж.Баясгалан: Байнгын хорооныхондоо өдрийн мэнд хүргэе. Тэгээд энэ Оюутолгойн төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, хэрэгжүүлэлтийн зарцуулалт, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэж байгаатай холбогдуулаад ажлын хэсэг байгуулагдсан. Тэгээд би Оюутолгой руу бол гишүүн болсноосоо хойш 3 удаа очиж үзсэн. Газартай нь, яг ажилтай нь танилцсан. Байгаа алдаа оноо хамаг юмыг нь бас харсан гишүүний хувьд бол энэ дээр заалнаас бас өөрийнхөө нэрийг нэмж өгөөч. Би энэ ажлын хэсэгт орж ажиллахыг хүсэж байна. Яагаад гэвэл бид нар үнэхээр энэ дээр ямар асуудал байгааг нь бол тал бүрээс нь харах ёстой. Тэрнээс биш цөөхөн хүн байлаа гээд давуу тал биш, харин олуулаа байж байж олон талаас нь харж байж алдаа оноог нь олж харах байх. Тэгээд 3 удаа очиж үзсэний хувьд бол би бас хэлж л байсан. Ийм ийм асуудлууд байна гэдэг. Тэгэхээр

тэр асуудлуудыг нь мэдэж байгаа учраас бас ил гаргахын тулд энэ ажлын хэсэгт орох шаардлагатай байна. Ингээд миний нэрийг ажлын хэсэгт нэмж оруулж өгнө үү гэсэн саналтай байна.

Ц.Даваасүрэн: Зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулна. Ганхуяг гишүүн үг хэлье.

Х.Ганхуяг: Нөгөө татварын ажлын хэсэгтэй холбоотойгоор бид нар бас нэлээн олон уулзалтууд хийгээд, энэ татвартай холбоотой нэлээн асуудлууд байгаад байна. Тэгээд яах вэ, зүгээр бас яах вэ ажлын хэсэг дээр нь байвал бид нар бас нэг олон нийтэд биш эхлээд ажлын хэсгийн хэмжээнд мэдээллүүдийг авчихвал сайн байгаад байна л даа. 2, 3 асуудал байгаа юм. Татвараас зугтаасан байж магадгүй. Тэгэхээр тийм учраас боломжтой бол манай Баясгалан гишүүн бас манай ажлын хэсгийн гишүүн. Тэгээд Баясгалан бид 2 орчихвол 2 намын төлөөлөл болоод ороод ажиллавал бас зүгээр юм болов уу гэж бодож байна дарга.

Ц.Даваасүрэн: 2 дахь гишүүн нэмэгдэж байна. Алтанхуяг гишүүн санал.

Н.Алтанхуяг: 2 санал байгаа. 1 дүгээрт байна шүү дээ. Нэг ажлын хэсэгт хүн оруулна гээд л хэдүүлээ цагаа бараад л. Ер нь Улсын Их Хурлын гишүүн хүн ард түмний төлөөлөгч юм чинь тэр ажлын хэсэгт ороод ажил төрөл хийе гэж байвал ажил төрлийг нь хийлгүүлмээр байгаа байхгүй юу. Тэр дээр нь бид нар кнопдоод л, энийг оруулна, тэрийг оруулна гээд л тэгээд 1 баахан юм яриад байх шаардлагагүй байна. Би Даваасүрэн даргад түрүүн микрофонгүй байхад хэлчихсэн. Бид нар чинь бас нэлээн хэдэн жил оймс элээж байгаа хүмүүс юм чинь хэдүүлээ санаачлаад нам гэхгүйгээр энэ чинь Их Хурлын гишүүний эрх байхгүй юу. Энийг нь ингээд одоо энэ Мөнхбаясгаланг яах уу гээд л. Мөнхбаясгалан намайг унагаачих юм болов уу гээд бүлтэлзээд. Үгүй ээ, ер нь энэ өнгөрсөн парламент дээр намайг тэр нүүрсний асуудлаар оръё гэсэн чинь Их Хурлын чуулган дээр ажлын хэсэгт оруулахгүй гэж унагааж байгаа шүү дээ. Энэ арай ч дээ. Хүн ажил хийе гэхээр май чи гэдэг ийм Парламент байх уу.

2 дахь нь сая бас Төсвийн байнгын хороо Байгаль орчин хуралдлаа л даа. Тэгээд гурилын гаалийн татвар яах вэ гээд. Үгүй ээ, сонгуулийн өмнө л сүр бар болж байгаад л одоо яг чухам хүү үнэ өртөг нь өслөө. Одоо ингээд л алаад өгнө. Та нар маань энийг 0 болговол амьдрал ахуй цэцэглэнэ гээд л оруулж ирээд л батлуулсан шүү дээ. Тэгээд сая болохоор одоо ер нь бас болохоо байлаа. Энэ бол түүхэн үүргээ гүйцэтгэлээ. Тэр солиот үгнүүдээ хасаарай тэр тогтоол дээрээс. Түүхэн үүргээ гүйцэтгэсэн учраас одоо энэ 0-ийг нь болиулаад тоог нь тавиад өгье. Ингэж явахгүй ээ. Энэ юу гэж хэлэх гэж байгаа вэ гэхээр би сая микрофонгүй Чойжилсүрэн сайдад хэлчихсэн. Танай Засгийн газар жаахан юм хумаа цэгцтэй, бодлоготой, үндэслэлтэй, тайлбартай, тэгээд ард иргэдээ бодсон, аж ахуйн нэгжээ бодсон юм оруулж ирж байгаач гэж хэлсэн юм. Одоо ер нь Их Хурал байна шүү дээ сүүлдээ Их Хурал биш болж байна. Бид хэд өөд өөдөөсөө хараад худлаа мар мар гэж байна гээд тоглоомын хэдэн амьтан боллоо шүү. Засаг дээрээ олигтойхон шийдчих юмыг л заавал бид нар луу авчирч шидээд, баахан хэрүүл болгох юм. Ингэж болохгүй ээ Их Хурлын гишүүд ээ, Даваасүрэн дарга аа. Даваасүрэн даргад шууд хамаатай юм байхгүй л дээ. Би зүгээр Даваасүрэн дарга бид нарт ч хамаатай. Ер нь танай нөгөө олонход их хамаатай шүү дээ. Одоо юм ярингуут л өөдөөс танайхан бас манайд ороод наалдчихаа биз дээ гээд л юм ярих юм. Үгүй ээ, тэр хамаагүй шүү дээ. Яах гэж наалдаж нийлцгээсэн юм. Энэ улс орны

амьдралыг сайжруулъя, энэ ард түмнийхээ ахуй амьжиргааг дээшлээд, аж ахуйн нэгжүүдээ дэмжье гэсэн. Аж ахуйн нэгжүүд овоо тариалаад явж байтал нь гэнэтхэн 0 болгож хаяад, баахан гурил оруулж ирчхээд, одоо ер нь буруу юм болсон байна. Тэгээд буруу гэж тэр Улсын Их Хурлын тогтоол дээр бичих ёстой байтал түүхэн үүргээ гүйцэтгэсэн учраас энэ 0-ийг нь тоогоор сольж байгаа юм. Ийм нэг дэмийрсэн, солиорсон юмнуудыг хэдүүлээ Их Хурал дээр яримаар байна. Манай Их Хурлын гишүүд жаахан өөрсдийнхөө эрх мэдлийг, ард түмнээс олгосон эрх мэдлээ авмаар байна. Ажилламаар байна. Хиймээр байна. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Санал хэллээ. Ойлголоо. Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Ингээд уг тогтоолд Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Л.Мөнхбаясгалан, Ж.Баясгалан, Х.Ганхуяг нарыг нэмж оруулъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 71.4 хувиар тогтоолд 4 гишүүнийг нэмж оруулахаар шийдвэрлэлээ.

Тогтоолын төслийг батал баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 14 гишүүн санал хураалтад оролцож, 11 гишүүн дэмжиж, 78,6 хувиар тогтоолын төсөл батлагдлаа. Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

11.54 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх, “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус 1 гишүүнийг Төсвийн байнгын хороо нэр дэвшүүлэхээр заасан. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111.6-д Байнгын хороо хуульд заасны дагуу албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэхдээ гишүүдээс санал болгосон нэр дэвшигч 1 бүрээр санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшүүлэхийг дэмжсэнд тооцно гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэхийг санал болгоно. Санал болгох гишүүн байна уу. Кнопоо дар. Мөнхсоёл гишүүнээр тасалъя. Нэр дэвшүүлэхээр санал болгож байгаа хүнээ танилцуулъя. Да.Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх Бөхбатын Бат-Эрдэнийг танилцуулъя.

Бөхбатын Бат-Эрдэнэ 1986 оны 1 сарын 13-нд төрсөн. 2003 онд Далай ван ЕБС-ийг төгссөн. 2007 онд ХИС-ийн Бизнесийн удирдлагын бакалавр, 2024 онд МУИС-ийн Бизнесийн сургуулийг Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй тус тус төгссөн.

Улсад 14 жил ажилласан бөгөөд үүнээс 11 жилийг санхүү, эдийн засгийн чиглэлээр төрийн байгууллагад ажилласан. Үүнийг тайлбарлаж тухайлбал Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мэргэжлийн боловсрол сургалтын газарт 2010-2011 онд мэргэжилтэн, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газарт 2012-2016 онд мэргэжилтэн, “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт 2016-2017 онд хэлтсийн дарга, “Улаанбаатар ЦТС” ТӨХК-д борлуулалт хариуцсан дэд захирлаар тус тус ажиллаж байсан ажлын туршлагатай бөгөөд одоо хувийн хэвшилд мэргэжлээрээ ажиллаж байгаа залуу боловсон хүчин юм.

Нэр дэвшигч Бөхбатын Бат-Эрдэнэ Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 11.5, 11.6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа болно.

Иймд Байнгын хорооны гишүүд хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Мөнхсоёл гишүүн танилцуулъя.

Б.Мөнхсоёл: Равжир овогтой Мөнхтөр 1979 онд төрсөн, эрэгтэй. Улаанбаатар хотын СБД-ийн 3 дугаар хороонд амьдардаг. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд өөрийнхөө нэрийг дэвшүүлж байгаа ийм хүн байна. Боловсролын хувьд МУИС-ийн Эдийн засгийн сургууль, эдийн засгийн магистрыг 2003 онд дүүргэсэн. Харин эдийн засгийн сургуулийн эдийн засагч, эдийн засгийн онолын багшаар 2001 онд бакалаврын зэрэг хамгаалсан ийм хүн байна.

Эрхэлсэн ажлын тухайд бол нэлээн олон их дээд сургуульд багшилж байсан. Тухайлбал МУИС-ийн Эдийн засгийн сургууль, Шинжлэх ухаан техникийн их сургуулийн Компьютер техник менежментийн сургууль гэх мэт сургуулиудад 2001-2016 онд багшилж байсан хүн байна. 2011-2016 онд Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар, Стратеги бизнес төлөвлөгөөний ахлах мэргэжилтнээр ажиллаж байсан. 2016-2018 онд Инвескор Санхүүгийн нэгдэлд ахлах эдийн засагч, дэд захирал, ТУЗ-ийн гишүүн, 2023 оноос “Эс Ай Би Жэй” компанийн Дэд захирал хийсэн. 2025 оноос “Жэй Өү Зи” компанид санхүү хариуцсан захирлын албыг хашиж байна. Тэгээд бас тус байгууллагуудад ТУЗ-ийн гишүүн байгаа юм байна. Жишээлбэл Хөрөнгийн бирж орж байна.

Ашиг сонирхлын бол зөрчилгүй. Банк болон ББСБ-ын хувьцаа эзэмшдэггүй. Харин саяын 2025 оноос үүсгэн байгуулсан энэ компанийнхаа хувьцаа эзэмшигч химийн технологи хөгжүүлэх зорилготой ийм компани юм байна.

Тэгээд өөрөө бас энэ өөрийнхөө нэр дэвшүүлэхдээ өгсөн энэ өргөдөл дотроо өөрийнхөө нэлээн олон хэвлүүлсэн материалын жагсаалтыг оруулсан байна. Жишээлбэл, Цалингийн бүтцийн судалгаа, Хөдөлмөрийн хөлсний 3 талт хэлэлцээрийн судалгаа, Монгол Улсад дотоод шилжих хөдөлгөөний нөхцөл үр дагавар судалгаа, Дунд орлогод ядуурах эмзэг байдлын судалгаа, Монгол Улсын хөдөө орон нутгийн санхүүгийн эрэлт хэрэгцээний талаарх судалгаа гээд нэлээн олон ийм ном тайлан дээр ажилласан ийм мэргэжлийн хүн байна. Тэгээд яагаад энэ албан тушаалд томилогдохыг өөрөө хүсэж байгаа, нэр дэвшүүлсэн үндэслэлээ тайлбарлахдаа нэлээн дэлгэрэнгүй ийм зүйлийг бичсэн байна.

Би товчхон хэлэхэд зохицуулалтын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр дэмжиж ажиллах боломж бүрдэнэ гэж үзсэн байна. Тухайлбал Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэхийн тулд хяналтын механизмыг шинэчлэх, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай гээд би яах вэ товчхон ганц өгүүлбэр хэлж байгаа шүү.

2 дугаарт нь хөрөнгийн зах зээлийг идэвхжүүлнэ.

3 дугаарт нь санхүүгийн боловсролыг дээшлүүлнэ.

4.Гадаадын хөрөнгө оруулалтыг татна.

5 дугаарт даатгалын салбарыг хөгжүүлнэ.

6-д нь пинтек инновацыг дэмжих чиглэлээр ажиллана гээд нэлээн дэлгэрэнгүй ийм анкет бөглөж ирүүлсэн байна. Ингээд товч танилцуулахад ийм байна. Мөнхтөр гэж нэр дэвшигчийг.

Ц.Даваасүрэн: Х.Ганхуяг гишүүн танилцуулга хийе.

Х.Ганхуяг: Монгол Улсын иргэн Монгол овогтой Болдбаатарын Ариунболдыг санал болгосон юм.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11.4, 11.5, 11.6 дахь хэсэгт заасан шаардлагыг бүрэн хангасан. Эхнэр, 1 хүүхдийн хамт амьдардаг.

ШУТИС-ийн КТМС-ийн Бизнес удирдлагын бакалаврын зэрэгтэй. Санхүү эдийн засгийн их сургуулийн Санхүү удирдлагын магистрын зэрэгтэй. Сөүлийн Хантан сургуульд мэргэжил дээшлүүлсэн. Америкийн англи хэлний академийн хэлний бэлтгэлийг дүүргэсэн. Санхүү, банкны тэргүүний ажилтан, Хөдөлмөрийн хүндэт медалиар тус тус шагнагдаж байсан.

Мөн Нэшнл Инженеринг группт ажиллаж байсан туршлагатай. Улаанбаатар Транс Фаст Рөүп, Хас банк, Сэлэнгэ Пресс, Монгол Улсын Хөгжлийн банк гэх мэтчилэн Монгол Улсын тэргүүлэх салбаруудад ажиллаж байсан банк санхүүгийн мэргэжилтэй залууг дэвшүүлэх гэсэн юм. Та бүхэн маань дэмжээд өгөөрэй.

Ц.Даваасүрэн: Ингээд Дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу нэр дэвшигч 1 бүрээр санал хураалт явуулах юм байна. Асуулт байхгүй юм байна.

Ингээд цагаан толгойн үсгийн дарааллын дагуу явчихъя. Эхний нэр дэвшигч Ариунболд.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягаас нэр дэвшүүлсэн Болдбаатарын овогтой Ариунболдыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 15-5 гишүүн дэмжиж, 33,3%-аар дэмжигдсэнгүй.

Баясгаланг протоколд авъя.

Дараагийнх нь Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатараас нэр дэвшүүлсэн Бөхбат овогтой Бат-Эрдэнийг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Батбаяр гишүүн горимын санал.

Д.Батбаяр: Санал хураалтад оролцсон боловч энэ төхөөрөмж гацаад, улаан бичиг гараад, тэгээд миний санал татгалзсанаар орчихлоо. Тэгэхээр горимын санал гаргаж байна. Энэ саяын саналыг хүчингүй болгоод, дахин санал хурааж өгнө үү гэсэн ийм саналтай байна.

Ц.Даваасүрэн: Батбаяр гишүүний гаргасан горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Сүүлийн удаа нэг хураачихъя. Анхаараарай. Мөнхтулга гишүүн саналаа хэлье.

П.Мөнхтулга: Хурууны хээ уншихад алдаа гараад, улаан бичиг гарч ирээд миний саналыг бүр оруулсангүй. Дахиж горимын санал гаргаж, санал хураалгах хүсэлтэй байна.

Ц.Даваасүрэн: Мөнхтулга гишүүний гаргасан горимын саналын дагуу санал хураалт явуулъя. Хүчингүй болгоё гэсэн саналын дагуу санал хураалт. Битгий чанга дар. Дэмжигдсэнгүй. Хэвээр үлдлээ.

Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Энэ 3 нэр дэвших хүсэлтэй хүн байсан юм байна. Ингээд харахаар гурвуулаа уначих магадлалтай юм байна. Тэгээд гурвуулааг нь сонголд оруулах ийм санал гаргамаар байгаа байхгүй юу.

Ц.Даваасүрэн: Болохгүй байх. Тэр бол дэг зөрчинө. Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Байнгын хорооны дарга аа, миний хажуу талд сууж байгаа Мөнхтулга гишүүн, Батбаяр гишүүн 2 хоёулаа ээлжилж дараад, нөгөө төхөөрөмж нь ажиллахгүй байгаа учраас саналыг илээр хураалгах горимын саналтай байна. Гараар хураалгах.

Ц.Даваасүрэн: Тэгвэл чиний саналыг дэмжье гэдгийг илээр санал хураалт явуулаад, дараа нь хүчингүй болгох санал хураалт явна шүү. Цогтбаатар гишүүний гаргасан горимын саналын дагуу санал хураалтыг техникийн саатлын улмаас гар өргөж, илээр хурааа гэдэг саналын томьёоллыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 15-10. Ингээд дэмжигдлээ.

Тэгвэл илээр санал хураалт явуулна.

Түрүүний саналуудыг хүчингүй болгоё гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. 15-9. Дэмжигдлээ.

Ингээд одоо илээр явуулна. Да.Цогтбаатар гишүүний нэр дэвшүүлсэн Бөхбатын Бат-Эрдэнийг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус

гишүүнээр нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 15-8. Дэмжигдсэн байна.

3 дахь санал хураалт. Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёлоос Мөнхсоёлоос нэр дэвшүүлсэн Равжир овогтой Мөнхтөрийг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор илээр явуулъя. Дэмжье гэсэн саналын томьёолол. 15-5.

Да.Цогтбаатараас нэр дэвшүүлсэн Бөхбатын Бат-Эрдэнийг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэхээр санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус 1 гишүүнд Төсвийн байнгын хорооноос нэр дэвшүүлэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 111.6-д заасны дагуу хэлэлцэж дууслаа.

“Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийн сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус албан тушаалд Төсвийн байнгын хорооноос нэр дэвшигчийн асуудлыг хэлэлцсэнтэй холбогдуулан хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулах тул Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулан та бүхэнд тараасан байгаа.

Нэр дэвшигчийн сонсголыг даргалах Улсын Их Хурлын гишүүн байна уу. Сонсголыг даргалах гишүүн. Чи өөрөө хэрэггүй. Ашиг сонирхлын зөрчилтэй болно. Баясгалан гишүүн даргална.

Би тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

“Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай”

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, 130 дугаар зүйлийн 130.1.1 дэх заалтыг үндэслэн Төсвийн байнгын хорооноос тогтоох нь.

1.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2.Нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгаланг томилсугай.

3.Нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг 2025-ны оны 5 4 дүгээр сарын 13-ны өдөр ...5 дугаар сар юм байна шүү дээ. Тэр нь буруу бичсэн байна шүү. 5 дугаар сарын 13-ны өдөр хүртэлх хугацаанд хүлээн авахаар тогтоосугай.

4.Нэр дэвшигчийн сонсголын талаар нийтэд мэдээлэх сонсголын бэлтгэл хангах ажлыг холбогдох хууль журмын хүрээнд заасны дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд даалгасугай гэсэн ийм тогтоол байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуух асуулттай, үг хэлэх гишүүн байна уу. Алга байна.

“Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолыг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Илээр явуулж байгаа. 15-9. Тогтоолын төсөл батлагдлаа.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдаан дууссаныг мэдэгдье. Баярлалаа гишүүд ээ.

12.10 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ